



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/82

Улаанбаатар хот

Тушаал хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Их хурлын 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг хүчингүй болсонтой холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Эм, эмнэлгийн хэрэгсэлд импорт, экспортын лиценз олгох журам батлах тухай” А/407 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

2. “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3 дахь хэсэгт заасан зохицуулалтын чиг үүргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт үүрэг болгосугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.

САЙД С.  С.ЧИНЗОРИГ

141223409